

## ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн байцгаана уу,

Бага ангийн сурагчид маань 12 сарын 7-ны Даваа гарагт хичээлдээ орно гэдгийг та бүхэнд дуулгахад баяртай байна. Бид бага ангийн сурагчдаа сургуульдаа буцаж ирэхийг хүлээж байна. Манай сургуулийн номын сангийн каталог вэб сайтанд тавигдсан болохыг та бүхэнд бас дуулгая. ОУДС-ийн вэб сайтын “Resources” мэдээллээс та бүхэн номын сангийн каталогийг харах боломжтой.

Та бүхэн даалгавраа цагт нь хийж дуусгахад хүүхдүүддээ урам өгөөрэй. Сурагчид маань бүрэн дүүрэн мэдээлэлтэй байж сурлагандаа түргэн хугацаанд амжилт гаргах боломжтой. Та бүхэн ОУДС сурагчдын ирцийн талаар нарийн журам баримталдагийг дахин анхаараарай. Сурагчид хичээлдээ тогтмол тасралтгүй сууснаар амжилттай суралцаж чадна гэдэгт бид итгэлтэй байдаг. Хэн нэгэн сурагчийн хичээлд суугаагүй өдөр нь 18-с илүү гарсан бол тухайн сурагч анги дэвших боломжгүй болох талтай.

Хичээл хаагдсан хүнд үед бидэнд тэвчээртэй хандаж байсан та бүхэнд баярлалаа. Сурагчиддаа хамгийн шилдэг боловсрол эзэмшүүлэхийн төлөө та бүхэнтэй хамтран ажиллаж байгаадаа бид баяртай байна.

**Захирал, Greg Rayl**

## ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Бид энэ долоо хоногт тасралтгүй 5 хоног хичээллэж сургуулийн хичээлийн хуваарь хэвийн байдлаар үргэлжилсэнд багш, сурагчид бүгд баяртай байгаа бөгөөд эцэг эхчүүд та бүхэн ч бас баярлаж байгаа гэдэгт би итгэлтэй байна. Сурагчид маань хичээлдээ шамдан суралцаж биднийг баярлуулж байгаа бөгөөд та бүхэн хичээлийн бус цагаар тэдэнд тусалж дэмжиж байгаад талархал илэрхийлье.

Mr. Ricketts хичээлийн ирцэд хяналт тавьж хоцорсон болон хичээлд ирээгүй сурагчдыг бүртгэж байгаа. ОУДС-н бодлого журам болон ирцийн журмыг нарийн чанд дагаж мөрдөх нь чухал байдаг. Иймээс та бүхэн хүүхдүүдээ өдөр бүр хоцролгүй цагтаа ирэхэд нь тусалж ирээгүй өвдсөн тохиолдолд бидэнд утсаар мэдээлж байх хэрэгтэй. Сурагчид хичээлийн жилд шалтгаантай болон шалтгаангүй байдлаар хичээлд ирэхгүй байх өдөр нь 18-с хэтрэх ёсгүй. Хэрвээ та бүхэн хүсвэл би уулзаж энэ талаар ярилцах боломжтой тул уулзалтын цаг авч болно.

Өвлийн амралтаар 3 долоо хоног гадагшаа явах гэж байгаа эцэг эхчүүдэд сануулахад ахлах ангийн сурагчдын шалгалтыг улирлын төгсгөлд буюу 1 сарын 20-25-ны өдрүүдэд авна. 2-р улирал буюу 1-р семестр нэг сарын 29-нд дуусч сурагчдын дүн 2 сарын 5-нд гарна. Олонх олон улсын сургуулиудын танхимд хичээллэх өдөр 180 хоног байдаг. 1 сарын 29-нд бид 91 хоногоо дуусгана. H1N1 вирусын халдвар дэгдсэний улмаас засгийн газраас авч хэрэгжүүлсэн хичээл хаах өдрүүдийг оруулж тооцсон болно.

Та бүхэнд тодруулж хэлэхэд Кристмасын баяр болон Шинэ Жилийн баярын амралт эхэлсэнээр хичээлийн жилийн улирал дуусдаггүй. Хичээлийн жилийн нийт хичээллэсэн хоногтой улирлын эхлэх дуусах хугацаа таарч байх ёстой. Хотоос холгүй цанын шинэ бааз ашиглалтанд орж олон хүмүүс нээлтийн ажиллагаанд оролцсон гэж бид дуулсан. Та бүхэн амралтаараа цанын баазад очиж үзээрэй. Анхаарал болгоомжтой байхаа мартуузай.

**Дунд Сургуулийн Эрхлэгч  
Betsy Hanselmann**

## ОУДС-ийн Мини НҮБ-ын хуралдаан

12 сарын 16-нд ОУДС дээр жил бүр зохиогддог мини НҮБ-ын хуралдаан болно. Энэ хурлын үеэр сурагчид дэлхийн улс орнуудын талаар их зүйлийг мэдэж НҮБ хуралдаанаа хэрхэн явуулдаг талаар туршлага олж авдаг арга хэмжээ юм. Сурагчид энэ хуралдаанд бэлтгэж өөрсдийн сонгож авсан орны талаар мэдээлэл бэлтгэх ёстой. 6-10-р ангийн сурагчдад хичээлийн үеэр мэдээлэл хайх цаг гаргаж өгөх болно. Эцэг эхчүүд та бүхэн хүүхдүүддээ мэдээлэл олж авахад нь туслаарай. Энэ өдөр

сурагчид хичээлдээ албан ёсны хувцас өмсөж ирэх хэрэгтэй. Хэрвээ та бүхэнд асууж лавлах зүйл байвал MUN-ий Зохицуулагч Mrs. Wilson болон Ерөнхий Нарийн Бичгийн Дарга Энхзаяатай (eggi\_adiya@yahoo.com) холбоо барина уу.

Сурагчдын Зөвлөл 12 сарын 11-ний Баасан гарагт **Wacky Hair Day** зохион байгуулна. Та бүхэн энэ өдөрт зориулж үсээ өөрчлөн янзлаарай.

### **БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Бага сургуулийн сурагчид 12 сарын 7-ны Даваа гарагт хичээлдээ буцаж орох болсонд бид баяртай байна. Бид ариун цэврийг дээд зэргээр үргэлжлүүлэн сахих болно. Хүүхэд тань өвдсөн бол хичээлд нь ирүүлэлгүй гэртээ байлгахыг та бүхэнд сануулж байна. Та бүхэн гэрээрээ хүүхдүүддээ хичээл зааж мөн сургууль дээр богино цагаар хүүхдүүдээ бататгах хичээлд ирүүлж байсанд баярлалаа.

Сүүлийн нэг сар хүн бүрийн хувьд амаргүй байсан бөгөөд эцэг эхчүүд та бүхэн биднийг дэмжиж ажиллаж байсанд баярлалаа. Манай багш нар сурагчдын гэртээ бие дааж хийсэн хичээлүүдийг үзэж, мөн сургууль дээр ирж бататгах хичээлд оролцож байгааг хараад бахархаж байна. Өвлийн амралт эхлэхээс 2 долоо хоногийн өмнө та бүхэн сургуульдаа эргэж ирж байгаад бид баяртай байна.

**Бага Сургуулийн Эрхлэгч  
Jan Wiggins**

### **БИЕЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС**

Сагсны тэмцээнд оролцох охидын баг бүрдэж дууслаа. Тэд өвлийн амралтын өмнө 12 сарын 10-ны Пүрэв гарагт Хобби сургууль, 12 сарын 15-ны Мягмар гарагт Америкийн Дунд Сургуулийн багуудтай тус тус тоглоно.

Охидын багийн бүрэлдэхүүн: Niba, Сарантөгс, Байгаль, Сугармаа, Хулан, Rebekah, Урангоо, Энх-Эрдэнэ, Mila, Jill

Хөвгүүдийн баг энэ долоо хоногт эцэслэн бүрдэж тэд Хобби сургууль, Америкийн Дунд Сургуулийн багуудтай тус тус тоглоно.

Сургуулийн дотоод тэмцээн: Өнгөрсөн Бямба гарагт волейболын тэмцээн амжилттай болж өнгөрлөө. Улаан багийн тамирчид ялалт байгуулсан. Цэнхэр багийнхан Ногоон багийн тамирчидтай эн тэнцүү өрсөлдөж онооны давуугаар яллаа.

Тэмцээний дүнгээс танилцуулбал:

Улаан 25 Ногоон 8; Улаан 25 Цэнхэр 20; Ногоон 25 Цэнхэр 16; Улаан 15 Ногоон 8  
Улаан 15 Цэнхэр 4; Цэнхэр 15 Ногоон 10

Энэ Бямба гарагт сургууль дээр SAT шалгалттай тул тэмцээн болохгүй. Охидуудын хөл бөмбөгийн баг гадаа цагтаа, хөвгүүдийн сагсны бэлтгэл 2:00 цагаас эхэлнэ.

**Биеийн Тамирын Тэнхмийн Эрхлэгч  
David Ricketts**